

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар болон хууль, журмын зохицуулалт
1	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг нийслэлд хаанаас авах боломжтой вэ?	Улаанбаатар хотод хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 7 газраас авах боломжтой.	<ul style="list-style-type: none"> - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар; Улсын бүртгэлийн үйлчилгээний 2 дугаар байр /100 айл/ - Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг “Инвест монголиа” нэг цэгийн үйлчилгээ төв; - Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс; - БЗД дэх Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний Дүнжингарав төв; - БГД дэх Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний Баянгол нэгдсэн төв - СХД дэх Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний Драгон нэгдсэн төв; - ХУД дэх Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний Мишээл нэгдсэн төв;
2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хураамж, үйлчилгээний хөлсийг цахимаар төлж болох уу?	Боломжтой.	Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсийг Сангийн яамны төлбөрийн баримтын систем ebarimt.mn хаягаар төлөх боломжтой. Мөн Улсын бүртгэлийн үйлчилгээний 2 дугаар байр болон Нийслэлийн үйлчилгээний нэг цэгийн төвүүдэд байрлах КИОСК машинаар төлөх боломжтой.
3	Хуулийн этгээдийн талаарх мэдээллийг зөвхөн цаасан байдлаар лавлагаа авч харах уу?	www.opendata.burtgel.gov.mn цахим хуудсаар дамжуулан хуулийн этгээдийн нээлттэй мэдээллийг харах боломжтой.	Улсын бүртгэлийн ерөнхий хууль. 12.2.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн дараах мэдээлэл нээлттэй байна: 12.2.1.нэрийн сан; 12.2.2.хаягийн сан; 12.2.3.хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээлэл;
4	Хуулийн этгээдийн лавлагаа авахад хэд хоногт гарах вэ?	Хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор олгоно.	Хуулийн этгээдийн улсын бүртгэллийн тухай хууль 11.1.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн хувийн хэргээс лавлагаа авах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор холбогдох этгээдэд лавлагааг олгоно.
5	Хуулийн этгээдийн лавлагааг зөвхөн Улсын бүртгэлийн байгууллагад хандаж авах уу?	Улсын бүртгэлийн байгууллагад хандаж авахаас гадна төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас болон цахимаар авах боломжтой.	Улсын бүртгэлийн үйлчилгээний 2 дугаар байр болон Төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас цаасан байдлаар авах ба мөн www.burtgel.gov.mn цахим хуудсаар дамжуулан хуулийн этгээдийнхээ лавлагааг авах боломжтой.
6	Орон нутагт хуулийн этгээд байгуулахад Улаанбаатар хотоос нэр авч болох уу?	Болно. Хуулийн этгээдийн нэр баталгаажуулахад харьяалал харгалзахгүй.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 13.1.Шинээр, эсхүл өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах, эсхүл хуулийн этгээдийн нэр өөрчлөх тохиолдолд нэр авах хүсэлтийг хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд улсын бүртгэлийн байгууллагад нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй гаргана.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар болон хууль, журмын зохицуулалт
7	Хуулийн этгээдийн нэр баталгаажуулахад хураамж төлөх үү?	Үйлчилгээний хөлс 500 төгрөг төлнө.	Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ” 6.1.Хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах - 500 төгрөг.
8	Хуулийн этгээдийн нэрийг гадаад үг, үсгээр авч болох уу?	Болохгүй. Хуулийн этгээдийн нэрийг зөвхөн монгол хэлээр баталгаажуулан олгоно.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам” 3.4.Хуулийн этгээдийн нэр монгол хэлээр, кирилл үсгээр илэрхийлэгдсэн байна.
9	Хуулийн этгээдийн нэрийг тоогоор ялгаж авч болох уу?	Болохгүй. Жишээлбэл: Хуулийн этгээдийн нэрийн санд “Номин” гэсэн нэр бүртгэгдсэн байхад “Номин нэг”, “Номин хоёр” гэсэн байдлаар ялгаж нэр олгохгүй.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам” 3.10.3.Хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн нэрийн хойно тоо бичсэн тохилдолд бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй гэж үзэж баталгаажуулахгүй.
10	Үүсгэн байгуулагч заавал биечлэн очиж хуулийн этгээдийн нэрээ авах уу?	Хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах этгээд, гүйцэтгэх удирдлагаар ажиллах иргэн, эсхүл тэдгээрийн итгэмжлэлээр эрх олгосон этгээд гаргана.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам” 2.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.1-д заасны дагуу дараах этгээд хуулийн этгээдийн нэр авах, баталгаажуулах хүсэлтийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр улсын бүртгэлийн байгууллагад гаргана: 2.1.1.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч; 2.1.2.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага; 2.1.3.итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд.
11	Хуулийн этгээдийн нэрийг цахимаар авч болох уу?	www.les.burtgel.gov.mn цахим хуудсаар дамжуулан хуулийн этгээдийн нэр авах боломжтой. Хүсэлтэд эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллээ бүртгүүлж, нэрийн хайлт хийж, хүсэлтээ илгээнэ.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам” 2.2.Энэ журмын 2.1-д заасан этгээд хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг биечлэн, эсхүл цахим хэлбэрээр гаргаж болно.”
12	Баталгаажуулан авсан хуулийн этгээдийн нэр хэд хоногт хүчинтэй байдаг вэ?	Баталгаажсан хуулийн этгээдийн нэр 30 хоногийн дотор хүчинтэй байна.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам” 4.5.Энэ журмын 4.3, 4.4-т заасны дагуу баталгаажсан хуулийн этгээдийн нэр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар болон хууль, журмын зохицуулалт
13	Баталгаажуулан авсан хуулийн этгээдийн нэрийн хугацааг сунгуулан хадгалж болох уу?	Болно. Хүсэлт гаргаж 60 хүртэл хоногоор сунгаж болно.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам” 4.6.Энэ журмын 2.1-д заасан этгээд энэ журмын 4.5-д заасан хугацаа дуусахаас өмнө хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хугацааг сунгах хүсэлт гаргасан тохиолдолд уг хугацааг 60 хүртэл хоногоор сунгаж болно.
14	Компани шинээр үүсгэн байгуулсан бол хэд хоногийн дотор улсын бүртгэлд бүртгүүлэх вэ?	Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор бүртгүүлнэ.	Компанийн тухай хууль. 5.1.Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 13.4.Өргөдөл гаргагч шинээр болон өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдлийг тухайн хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулснаас хойш 30 хоногийн дотор улсын бүртгэлийн байгууллагад гаргана.
15	Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол хэд хоногт бүртгүүлэх ёстой вэ?	Ажлын 15 өдрийн дотор бүртгүүлнэ.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 10.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.
16	Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсныг бүртгүүлэхэд шийдвэрийн хамт хурлын тэмлэглэл байх шаардлагатай юу?	Шаардлагатай.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 22.1.3.Үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл;
17	Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн хэд байх вэ?	Удирдах зөвлөл 5-аас доошгүй сондгой тооны гишүүнтэй байна.	Төрийн бус байгууллагын тухай хууль. 11.3.Удирдах зөвлөл нь таваас доошгүй сондгой тооны гишүүдээс бүрдэнэ.
18	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахад санхүүгийн тайлан шаардлагатай юу?	Шаардлагатай.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 22.1.7.хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцэл.
19	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг компани хувьцаагаа бусдад шилжүүлэхэд татвараас зөвшөөрөл авах уу?	Тодорхойлолт авна.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 10.6.Хуулийн этгээдийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага холбогдох татвар төлсөн талаарх татварын албаны тодорхойлолтыг үндэслэн өөрчлөлтийг бүртгэнэ.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар болон хууль, журмын зохицуулалт
20	Эцсийн өмчлөгч гэж хэнийг ойлгох вэ?	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан хүнийг ойлгоно.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. 3.1.6.“эцсийн өмчлөгч” гэж: 3.1.6.а.харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг ;
21	Эцсийн өмчлөгчийг хэрхэн тогтоох вэ?	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 ¹ .1-д заасныг баримтлан тогтооно.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. 4 ¹ .1.Эцсийн өмчлөгчийг дараах дарааллаар шалгаж тогтооно: 4 ¹ .1.1.хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг ; 4 ¹ .1.2.энэ хуулийн 4 ¹ .1.1-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг ; 4 ¹ .1.3.энэ хуулийн 4 ¹ .1.1, 4 ¹ .1.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг .
22	Хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг эзэмшиж байгаа гэдгийг хэрхэн ойлгох вэ?	Хөрөнгийн 33 ба түүнээс хувийг эзэмшиж байгаа тохиолдолд дийлэнх хэсэгт үзэж бүртгэнэ.	Компанийн тухай хууль. 56.1.Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хувьцааны хяналтын багц гэнэ. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”. 4.3.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эцсийн өмчлөгчийг тогтооходоо Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 ¹ дүгээр зүйлд заасан дарааллыг баримтална. 4 ¹ .1.1-д заасан дийлэнх хэсэг гэдгийг шууд болон шууд бус хэлбэрээр нийт хувьцааны 33 хувийг өмчилж байгаа гэж ойлгоно. УБЕГ-ын 2020 оны А/1270 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам”. 3.2.Энэ журмын 3.1-д заасан “хөрөнгийн дийлэнх хэсэг” гэж ...тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн 33, түүнээс дээш хувийг ойлгоно.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар болон хууль, журмын зохицуулалт
23	Эцсийн өмчлөгчийн мэдээллийг заавал бүртгүүлэх үү?	Тийм. 2020.01.01-ний өдрөөс өмнө улсын бүртгэлд бүртгэлтгүүлсэн хуулийн этгээд бол 2021.01.01-ний өдрөөс өмнө эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлнэ. Шинээр үүсгэн байгуулагдаж буй хуулийн этгээд эцсийн өмчлөгчийн мэдээллээ мөн бүртгүүлэх бөгөөд цаашид өөрчлөлт орох бүрт өөрчлөлтийг ажлын 15 өдрийн дотор бүртгүүлнэ.	Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль. 9 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсантай холбогдуулан 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн этгээд нь тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 10.1.14.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл. 14.2.10.хуулийн этгээдийн хувьд эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл.
24	Эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлэхэд ямар баримт бичиг бүрдүүлэх вэ?	“Маягтын загвар шинэчлэн батлах тухай” УБЕГ-ын даргын 2020 оны А/1258 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-12 маягт/-ийг бөглөж, холбогдох баримт бичгийн хамт улсын бүртгэлийн байгууллагад ирүүлнэ.	“Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-12 маягт/-д дараах баримт бичгийг хавсаргана. - улсын бүртгэлийн гэрчилгээ. /эх хувь/ - эцсийн өмчлөгч нь гадаадын иргэн бол паспортын хуулбар; - үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар, эрх бүхий этгээдийн мэдээлэл; - улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт; /гадаадын хуулийн этгээдийн тухайд гэрчилгээний хуулбарыг монгол хэлнээ орчуулж, баталгаажуулсан байна./ Улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх хуулийн этгээдийн тухайд: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан баримт бичигтэй хамт УБ-12 маягыг бүртгүүлнэ. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх бол Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан баримт бичигтэй хамт УБ-12 маягыг бүртгүүлнэ.
25	Эцсийн өмчлөгчийн мэдээллээ хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй бол хариуцлага хүлээх үү?	Зөрчлийн тухай хуулийн 15.23 дугаар зүйлд заасны дагуу торгуулийн арга хэмжээ оногдуулна.	Зөрчлийн тухай хууль. 15.23 дугаар зүйл.Улсын бүртгэлд бүртгүүлэх журам зөрчих 1.Улсын бүртгэлд бүртгүүлэхээр мэдүүлэг гаргагч: 1.1.хуульд заасан үүргээ биелүүлээгүй; 1.2.хуульд заасан улсын бүртгэлийн мэдүүлэг, өргөдөл, хүсэлт, хавсаргасан нотлох баримтыг үнэн зөв мэдүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар болон хууль, журмын зохицуулалт
26	Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болох уу?	Болохгүй. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй.	Компанийн тухай хууль. 62.1.Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: 62.1.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
27	Үнэт цаасны үйл ажиллагаа эрхэлдэг компанийн захирал өөрчлөхөд Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх үү?	Тийм. Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдсэний дараа улсын бүртгэлд бүртгүүлнэ.	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль. 62.1.Үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь Хороо байна. 63.1.Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 63.1.9.зохицуулалттай этгээдийн удирдах албан тушаалтанд нэр дэвшигчийг тохиромжтой этгээд мөн эсэхийг тогтоох, түүнд ажиллах зөвшөөрөл олгох, эсхүл тохиромжтой бус этгээдийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх;
28	Хуулийн этгээд нэгдэх, нийлэх тохиолдолд хаана хандаж, дүгнэлт гаргуулах вэ?	Давамгай байдалтай хуулийн этгээд бол нэгдэх, нийлэх тохиолдолд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт хандаж, дүгнэлт гаргуулсан байна.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль. 20.1.10.“нэгдэх, нийлэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт;” Өрсөлдөөний тухай хууль. 8.1.Давамгай байдалтай хуулийн этгээд бусад этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй нэгдэх, нийлэх тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт өргөдөл гаргана.
29	Төрийн бус байгууллага компанийн хувьцаа эзэмшигч байж болох уу?	Болохгүй. Төрийн бус байгууллага ашгийн бус зорилготой үйл ажиллагаа эрхлэнэ.	Төрийн бус байгууллагын тухай хууль. 4.1.“Төрийн бус байгууллага” гэж иргэд, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг; 8.1.“Төрийн бус байгууллагыг дор дурдсан үндэслэлээр шүүх албадан татан буулгана:” гэж, мөн хэсгийн 1-д “дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан;” гэж тус тус заасан.
30	Компани байгуулахад үүсгэн байгуулагчийн тоонд хязгаар байх уу?	Байна. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн тоо 50-аас дээшгүй байна.	Компанийн тухай хууль. 5.1.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн байгуулах үеийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас дээшгүй байна.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР